



БАТЛАВ
"ДЦС-4" ТӨХК-ийн Гүйцэтгэх
ЗАХИРАЛ
У.ТӨМӨРХУЯГ



БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ийн
Гүйцэтгэх Захирал
М.МӨНХӨӨ

ҮНС ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТООЦОХ ТУХАЙ ГЭРЭЭ

2023 оны 11 сарын 29 өдөр
2023. 11. 30

№ 1/2023-628
2023/110

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "ДЦС-4" ТӨХК-ийг төлөөлж Борлуулалт маркетингийн албаны дарга С.Алтанхуяг /цаашид "гүйцэтгэгч" гэх/ нөгөө талаас "Амгалан дулааны станц" ТӨХК-ийг төлөөлж Ерөнхий инженер Э. Мөнхжаргал /цаашид "захиалагч" гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 476-482-р зүйлийн заалтуудыг үндэслэн хамтран ажиллаж дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү гэрээгээр захиалагчийн захиалгын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-аас гарсан хаягдал үнсийг /цаашид "үйлчилгээ" гэх/ ДЦС-4 ТӨХК-ийн зуухны үнс холигч /канал/ руу хийх болон үнсэн санд хаяж зайлуулах үйлчилгээ, захилагч үнийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой үүссэн харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 2.2 Талууд харилцан тохиролцсоноор энэхүү гэрээг 2023 оны 11-р сарын 24-ны өдрөөс 2024 оны 05-р сарын 01-ний өдөр дуустал хугацаатай доор дурьдсан нөхцөлтэйгээр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Гурав. Төлбөр, тооцоо

- 3.1 Талууд хоорондоо тохиролцсон үйлчилгээний төлбөр 1 тонн үнс зайлуулсаны үйлчилгээний хөлс үнсэн санд задгайгаар хаяхад 6600₮ /НӨАТ тооцсон үнэ/, тооцсон үнэ/-өөр тооцно.
- 3.2 Хаягдал үнсийг ДЦС-4 ТӨХК-ийн үнс холигч канал руу хаясан болон үнсэн санд задгай хаясан хэмжээгээр, нэхэмжлэлийг үндэслэн ДЦС-4 ТӨХК-ийн дансанд төлнө.

Дөрөв. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч тал гэрээний хугацаанд үйлчилгээ үзүүлсний үнийг захиалагчаас нэхэмжлэх эрхтэй.
- 4.2. Захилагч тал гэрээнд заасан хугацаанд төлбөрийн тооцоог бүрэн барагдуулаагүй бол гүйцэтгэгч тал цаашид үйлчилгээ үзүүлэхгүй байх эрхтэй.
- 4.3. ДЦС-4 ТӨХК-ийн Хяналтын албанаас тавьсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, Аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

- 4.4. Станцын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн, эд зүйл эвдсэн, хулгайлсан, архи уусан, хэв журмын зөрчил гаргасан гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээг цуцлах эрхтэй.
- 4.5. Гүйцэтгэгч тал "Амгалан дулааны станц" ТӨХК-д дараахь дугаартай тээврийн хэрэгсэлийг нэвтрүүлнэ Үүнд: **Норд бенз:28-74 УНЯ, Хово:47-43 УБУ** үнсний машин.
- 4.6. Техникийн шалтгаанаар, тодорхой хугацаанд үнс зайлуулах боломжгүй болсон тохиолдолд захиалагч талд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Тав. Захиалагч талын эрх, үүрэг

- 5.1. Гэрээгээр тохиролцсон захиалгын дагуу, хаягдал үнсийг саадгүй хүлээн авч зайлуулж байхыг гүйцэтгэгч талаас шаардах эрхтэй.
- 5.2. Захиалагч тал үйлчилгээний төлбөрийг сар бүрийн сүүлийн 7 хоногийн ажлын эхний 3 хоногт бүрэн дуусгаж, төлбөрийн тооцоогүй болсон байх үүрэгтэй.
- 5.3. Үүргээ гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээгээр тогтоосон хэмжээгээр алданги төлөх үүрэгтэй.
- 5.4. Захиалагч нь тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж, замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.
- 5.5. Гадаа үнсэн санд задгай хаясанаас үүсэх хариуцлагыг захиалагч тал бүрэн хариуцна.

Зургаа. Талуудын хүлээх эрх, үүрэг

- 6.1 Гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3%-ийн алдангийг захиалагчид төлөх үүрэгтэй.
- 6.2 Захиалагч тал гэрээний 5.2-т заасан хугацааг хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3%-ийн алдангийг Гүйцэтгэгч талд төлөх үүрэгтэй.
- 6.3 Торгууль алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.4 "ДЦС-4" ТӨХК-ийн Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Компаний дотоод журмыг зөрчсөнөөс, түүнчлэн өөрсдийн буруугаас тоног төхөөрөмж гэмтээсэн, үйлдвэрлэлийн осол гэмтэл гаргасны улмаас учирсан хохирлыг Захиалагч байгууллага хариуцаж, хохирлыг барагдуулна.
- 6.5 Гэрээний хугацаа дуусахад 2 тал хамтарч гэрээг дүгнэнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл /Форсмажор/

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэнд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйл мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар гэрээг цуцлана.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд Форсмажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах







- 8.1 Аль нэг тал гэрээнд заасан үүргээ зөрчсөн, зохих ёсоор биелүүлээгүй буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрэв талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцож хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарснаар хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Талуудын аль нэг нь гэрээнээс татгалзах бол нөгөө талдаа 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдлийг хүлээн авсан тал 10 хоногийн дотор уг мэдэгдлийн талаар өөрийн байр суурь, саналыг бичгээр хариу мэдэгдэнэ. Хэрэв гэрээг биелүүлэх боломжгүй болох нь тодорхой бол нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

Ес. Бусад зүйл





- 9.1 Талууд энэхүү гэрээг Монгол хэл дээр 2% үйлдэж захиалагч тал 1% -ыг гүйцэтгэгч тал 1% -ийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй.
- 9.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

ДЦС-4" ТӨХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  П.БОЛДБААТАР
БМА-НЫ ДАРГА  С.АЛТАНХУЯГ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  Д.ТӨМӨРТОГОО
ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  Л.ГАНБОЛД
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ  Ч.БЯМБАСҮРЭН
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН  С.ДОНИД

Захиалагч талыг төлөөлж:

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК- ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Э. МӨНХЖАРГАЛ
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ  О. УДВАЛ
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  Г. САРУУЛ
ГЭРЭЭ, БОРЛУУДАЛТЫН ИНЖЕНЕР  Б.БАТЦООЖ

АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

РД:2688352

Харилцах банк:ХХБ 806-р салбар

Дансны дугаар: 406001049

Харилцах банк: Төрийн банк

Дансны дугаар:102100001107

РД: 2061646

Харилцах банк:ХХБ

Дансны дугаар:464018009

Харилцах банк: Төрийн банк

Дансны дугаар:106000036534

Гүйцэтгэгч

Захиалагч

Харилцах банк:ХААН банк

Дансны дугаар:5038008126

Харилцах банк:Голомт банк

Дансны дугаар:1102038052

Харилцах банк:Капитал банк

Дансны дугаар:2002017630

Харилцах утас:7000-2245

7017-0783

7000-1184

Байршлын хаяг:

Баянгол дүүрэг 20-р хороо
Эрчим хүчний гудамж

Харилцах банк: ХААН банк

Дансны дугаар:5131101050

Харилцагч банк: Голомт банк

Дансны дугаар:3105103284

Мейл хаяг: battsooj.b2@gmail.com

Харилцах утас: 7711-1244

7711-1257

99047300,99662289

Байршлын хаяг:

УБ хот, БЗД, 8-р хороо УС-15-1-1 Ботаникийн эцэс